МОНГОЛ ШУУДАН

“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 15 өдөр Дугаар 23/01 Улаанбаатар хот

2022 оны ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 4.16 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь заалт, Улсын их хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 675 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ХК-ийн 2022 оны цэвэр ашгийн дүнгээс 50 хувиар тооцож нийт 225,641,500.00 (хоёр зуун хорин таван сая зургаан зуун дөчин нэгэн мянга таван зуун) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Нэгж хувьцаанд 2.26 (Хоёр төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн ногдол ашиг тараахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхбаатар/-д үүрэг болгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тарааж эхэлсүгэй.
5. Энэхүү ногдол ашиг хураарилалтын шийдвэр болон 2021 оны ногдол ашиг тараасан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /Д.Балдорж/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ ШУУДАН ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ УЛААНБААТАР ХОТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ